



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 06 дугаар сарын 12  
№22 (1417)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

78. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай 975

79. Хэлэлцээр соёрхон батлах тухай 980

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

80. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 15 981

81. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 21 989

82. Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай Дугаар 22 990

83. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 24 992

### МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

84. Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 993

85. Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протокол 999





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 05 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАДААД ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуульд заасан төслийн санхүүжилтийг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулсан эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

##### 2 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

2.1.Энэ хуулийн үйлчлэлд гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх дараах төсөл хамаарна:

- 2.1.1.газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл;
- 2.1.2.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл.

2.2.Гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 2.1-д заасан төслийн нэрийг өөрчлөх, шинэ төсөл нэмэхийг хориглоно.

2.3.Гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ ГАДААД ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, НЭГДСЭН ТӨСӨВ ХООРОНДЫН ХАМААРАЛ

##### 3 дугаар зүйл.Гадаад зээлийн ашиглалтын зардал

3.1.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ энэ хуулийн 2.1-д заасан

төслийн гадаад зээлийн тухайн жилийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болох бөгөөд нэмэгдсэн дүн нь уг хязгаарт хамаарахгүй.

3.2.Тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал нь энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ**

#### **4 дүгээр зүйл.Гадаад зээлийн ашиглалтын хяналт, ил тод байдал**

4.1.Засгийн газар энэ хуулийн биелэлтийн талаарх тайланг тухайн жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хамт Монгол Улсын Их Хуралд хүргүүлнэ.

4.2.Энэ хуулийн 2.1-д заасан төслийн хэрэгжилт, санхүүжилт, гадаад зээлийн ашиглалттай холбоотой мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олон нийтэд ил тод, нээлттэй, тогтмол мэдээлнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **5 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журам**

5.1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар баталсан гадаад зээл, тусламжаас санхүүжих зардлаас энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалтад санхүүжүүлсэн зардлыг энэ хуулийн 3.1, 3.2-т заасан зохицуулалтад хамруулна.

5.2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10.2-т заасан Засгийн газрын авч ашиглах гадаад зээлийн дээд хэмжээ нь энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

5.3.Энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалт бүрэн дуусах хүртэлх хугацаанд энэ хуулийг дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**С.БЯМБАЦОГТ**









## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 05 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” хэлэлцээр болон уг хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Үсэнтэй ажлаар мэдэгдсэн

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА  
С.БЯМБАЦОГТ

Үсэнтэй ажлаар мэдэгдсэн  
МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

### **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг бүрдүүлэх, үнэлэхэд гарч байгаа алдаа дутагдал, хууль зүйн туслалцаа авах эрхийг зөрчиж, хязгаарлаж байгаа явдал, хүний халдашгүй байх эрх зөрчигдөх нөхцөл арилахгүй байгаа төдийгүй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль зөрчсөн шийдвэр, шүүхийн хараат бус байдалд эргэлзээ үүсгэх нөхцөл, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэтрүүлэн хэрэглэж байгаа явдал нь тухайн тохиолдол бүрийн алдаа бус, системийн шинжтэй доголдол мөн болохыг тэмдэглэж, тэдгээрийг арилгах, хүний эрхийн баталгааг бодитой хангах зорилгоор дараах бодлогын болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т үүрэг болгосугай.

1/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийн суурь баталгааг бодитой хангах зорилгоор дараах арга хэмжээг шалгуур үзүүлэлт, тогтмол хяналт, шинжилгээ, хариуцлагын тогтолцоонд тулгуурлан хэрэгжүүлэх:

а/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчгүйгээр байцаалт явуулах, мэдүүлэг авах хууль бус явдлыг бүрэн таслан зогсоож, байцаалт бүрийг өмгөөлөгчийн оролцоотой явуулсан эсэхийг бүртгэлжүүлэх, зөрчлийн тохиолдлыг улирал тутам тайлагнах, илэрсэн зөрчилд сахилгын болон хууль, эрх зүйн хариуцлага ногдуулах нэгдсэн журам баталж мөрдүүлэх;

б/цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэрэглээг хуульд заасан үндэслэл, шалгуурт нийцүүлэн хатуу хязгаарлах, цагдан хорих шийдвэрийн үндэслэл, хугацаа, сунгалтыг нэгдсэн сангаар бүртгэх, сар бүрийн хяналт, шинжилгээгээр шалгуурт нийцээгүй тохиолдлыг илрүүлж, бууруулах зорилтот үзүүлэлт тогтоох, үндэслэлгүй хэрэглэсэн тохиолдолд хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх;

в/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байх хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж, ийнхүү олж авсан нотлох баримтыг шүүхийн шатанд хассан тохиолдлын тоо, үндэслэл, шалтгаан, холбогдох этгээдэд хариуцлага тооцсон эсэх талаар тогтмол нэгтгэн дүгнэж байх, прокурорын хяналтын шатанд нотлох баримтын хууль ёсны байдлыг урьдчилан хянах механизмыг бүрдүүлэх;

г/эрүүгийн хэрэг хаах, сэргээх, хөөн хэлэлцэх хугацаа тооцох асуудлаарх хууль хэрэглээний зөрүүг арилгах зорилгоор нэгдсэн тайлбар, аргачлал батлан мөрдүүлэх, шүүх, прокурорын байгууллагын практикт гарч буй зөрүүг хагас жил тутам нэгтгэн дүгнэж, шаардлагатай тохиолдолд тайлбар, аргачлалыг шинэчлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах;

д/прокурор, мөрдөгчийн хүний эрхийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг системтэйгээр дээшлүүлэх хүрээнд сургалтыг жил бүрийн батлагдсан хөтөлбөрөөр тогтмол зохион байгуулах, оролцоо, үнэлгээ, ахицын шалгуур үзүүлэлт тогтоох, хяналт, шинжилгээ, гүйцэтгэлийн үнэлгээг хүний эрхийн шалгуур үзүүлэлттэй уялдуулж, сахилга, хариуцлагын тогтолцоог бодитоор хэрэгжүүлэх.

2/“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.1.1.1-д “Иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх ... чиглэлээр Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг тодотгоно.” гэж, 4.2.1.14-т “Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана.” гэж заасныг тус тус хэрэгжүүлэх хүрээнд дараах асуудлыг тусган холбогдох хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх:

а/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах бие даасан албыг шинээр байгуулах асуудлыг тусган холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

б/хохирогчийн эрхийг сэргээх зохицуулалтын хүрээнд эрүү шүүлт, хууль бус баривчилгаа, хилс ял, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчлөөс үүдэн хохирсон иргэдийн эрхийг сэргээх, нөхөн төлбөр олгох, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн үйлчилгээ үзүүлэх.

3/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллах чиг баримжаа давамгайлсан тэнцвэр алдагдсан тогтолцоог өөрчилж, хүний эрхийн баталгааг бодитойгоор хангах зорилгын хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цогц шинэчлэх асуудлаар дараах саналыг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулах:

а/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дээд шатны прокурорт гомдол гаргаж шийдвэрлүүлэх зохицуулалтыг өөрчилж, прокурорын зарим чиг үүргийг шүүхэд шилжүүлэн, мөрдөн шалгах ажиллагаанд шүүхийн хяналтыг тодорхой болгож, прокурор, өмгөөлөгчийн шүүхийн өмнө тэгш байх зарчмыг хангах;

б/өмгөөллийн үйл ажиллагааг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бодит нөлөө үзүүлэх, хүний эрхийн хамгаалалтын бие даасан механизм болох чиглэлд өөрчилж, өмгөөлөгчийн оролцооны зайлшгүй байдлыг хангах, хууль зүйн туслалцааг бодитойгоор хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

в/мөрдөгч, прокурорын зүгээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан хүний эрхийн болон хуулийн зөрчилд ногдуулах хариуцлага зайлшгүй байх механизмыг бий болгож, ил тод, үр нөлөөтэй хяналт, шинжилгээ, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх.

4/Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид төрөөс нөхөн олгосон төлбөрийг тухайн гэмт хэргийг үйлдсэн буруутай этгээдээр буцаан бүрэн төлүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, уг гэмт хэргийг үйлдсэн этгээдийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийг бий болгон хуульд нийцүүлэн хөтлөх, ашиглах журмыг баталж, мөрдүүлэх.

5/Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг эрүүдэн шүүх гэмт хэрэг болон хүний эрх, эрх чөлөөний зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүний эрх, мэргэжлийн ёс зүй, хууль дээдлэх зарчимд суурилсан тасралтгүй сургалт, давтан бэлтгэлийг тогтмол зохион байгуулж, мөрдөн шалгах ажиллагаанд хууль бус арга хэрэглэхийн хууль зүйн үр дагавар, хүний эрхэд учруулах хор уршгийг бодит жишээ, практикт тулгуурлан ойлгуулах, байцаалт, мэдүүлэг авах ажиллагаанд дуу-дүрсний бичлэг хийх, өмгөөлөгчийн оролцоог хангах талаарх сургалт, дотоод хяналтыг сайжруулах, алба хаагчдыг хууль зөрчих нөхцөлд хүргэдэг ажлын ачаалал, гүйцэтгэлийн дарамт зэрэг хүчин зүйлийг бууруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах.



2.Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан зохион байгуулалт болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинээр бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**С.БЯМБАЦОГТ**

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Հասցե

Հասցե և հեռախոսի համարներ

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները  
Իրենց խմբի անդամները  
Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները

Իրենց խմբի անդամները









**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 05 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар  
хот

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасгай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**С.БЯМБАЦОГТ**

Үргэлжлэлтэй хууль төсөл

2026 оны 5 сарын 22-ны өдөр /сүхбаатар хотын төв дүүргийн 10-дугаар хороо/

Төсвийн төсөл

Монгол Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улаанбаатар хот, 2026 оны 5 сарын 22-ны өдөр. Төсвийн төсөл /сүхбаатар хотын төв дүүргийн 10-дугаар хороо/

Монгол Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улаанбаатар хот, 2026 оны 5 сарын 22-ны өдөр. Төсвийн төсөл /сүхбаатар хотын төв дүүргийн 10-дугаар хороо/

Үргэлжлэлтэй хууль төсөл

2026 оны 5 сарын 22-ны өдөр



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хот

### Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабалыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны даргаар сонгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддоржийг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**С.БЯМБАЦОГТ**





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар  
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

2026 оны 05 сарын 29 өдөр /МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР /

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.Бямбацогт /МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА /

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
С.Бямбацогт /МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА /

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
С.Бямбацогт

2026.05.29

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

#### БОЛОН

#### ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар (цаашид “Талууд” гэх),

Эрх тэгш, харилцан ашигтай, урт хугацааны хамтын ажиллагааны зарчим дээр тулгуурлан,

Талуудын хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, эрчим хүчний салбарт Монгол, Оросын харилцааг цаашид гүнзгийрүүлэх эрмэлзлээ нотолж,

Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай 2019 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн гэрээ болон Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1995 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хэлэлцээрийг тус тус харгалзан,

Дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

#### Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн гуравдугаар зүйлд заасан Талуудын итгэмжлэгдсэн байгууллагууд Оросын Холбооны Улсаас Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх болон энэхүү Хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлд заасан хамтарсан компанийн үйл ажиллагааг эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд Хэлэлцээрийн зорилго оршино.

#### Хоёрдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг дараах эрх бүхий байгууллагууд гүйцэтгэнэ. Үүнд:

Монголын талаас - Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам;

Оросын талаас - Оросын Холбооны Улсын Эрчим хүчний яам.

Эрх бүхий байгууллагууд өөрчлөгдсөн тохиолдолд Талууд бие биедээ энэ тухай дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ.

### **Гуравдугаар зүйл**

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Талууд дараах итгэмжлэгдсэн байгууллагуудтай байна. Үүнд:

Монголын талаас – “Эрчис ойл” ХХК ба/эсхүл түүний хамаарал бүхий байгууллагууд;

Оросын талаас – “НК Роснефть” НХН ба/эсхүл түүний хамаарал бүхий байгууллагууд.

### **Дөрөвдүгээр зүйл**

1. Талуудын эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын “Чингис хаан” олон улсын нисэх буудлын (ICAO-ийн нисэх буудлын код: ZMCK) (цаашид “Байгууламж” гэх) дэд бүтцийг удирдах болон ашиглах Хамтарсан компани байгуулна.

2. Хамтарсан компани нь “Чингис хаан” нисэх буудалд агаарын хөлгийн түлшийг тасралтгүй, тогтвортой, саадгүй хангах болон агаарын хөлгийг түлшээр цэнэглэх үйлчилгээ үзүүлэх зорилгоор Байгууламжийг удирдах болон ашиглах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3. Хамтарсан компанид агаарын хөлгийн түлш нийлүүлэх ажлыг Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага хэрэгжүүлнэ.

4. “Чингис хаан” нисэх буудалд агаарын хөлгийн түлш худалдах (үүнд нийлүүлэх, хадгалах, цэнэглэх, борлуулах, хүргэх, тээвэрлэх) үйл ажиллагааг хамтарсан компани хийж гүйцэтгэнэ.

5. Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын дотоодын зах зээлд газрын тосны бүтээгдэхүүнийг борлуулах үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу тогтоосон хязгаарлалтууд үйлчлэхгүй байх асуудлыг хангана.

6. Байгууламжийн хэрэгцээнд агаарын хөлгийн түлш тасралтгүй нийлүүлэх үйл ажиллагаанд саад учруулсан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Талуудын итгэмжлэгдсэн байгууллагууд даруй хэлэлцээ хийж, эрх бүхий байгууллагуудад энэ тухай мэдээлнэ.

### **Тавдугаар зүйл**

Хамтарсан компани нь Байгууламжийг үр дүнтэй ашиглах зорилгын хүрээнд Монголын тал дараах баталгааг өгнө. Үүнд:

Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагад Байгууламжийг ашиглахад шаардлагатай зөвшөөрлийн баримт бичгүүд, лиценз болон бусад баримт бичгийг олгох,

Байгууламжийн удирдлага, ашиглалт, хөгжүүлэлттэй холбоотой үйл ажиллагааны хүрээнд Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага болон түүний туслан гүйцэтгэгч байгууллагын албан хаагчдад Монгол Улсын хилээр нэвтрэх, гарах, Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суух, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх,

Байгууламжийг ашиглах, хөгжүүлэхэд шаардлагатай бараа материал, барилга угсралтын техник болон тоног төхөөрөмжийг Монгол, Оросын улсын хилээр хил, гаалийн хялбарчилсан горимоор нэвтрүүлэх,

Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага болон түүний туслан гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанд эрх тэгш орчныг бүрдүүлэх, түүнчлэн хөрөнгө оруулалтыг ялгаварлан гадуурхахгүй, хууль ёсны дагуу хамгаалах,

Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага Монгол Улсын аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний дагуу шаардлагатай хэмжээгээр агаарын хөлгийн түлш нийлүүлэхэд Монгол Улсын хуулийн этгээд болон гуравдагч улсын хуулийн этгээдэд ижил төрлийн газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэхэд Монголын талаас олгодог нөхцөлөөс дутуугүй таатай нөхцөлд үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх,

Хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой төлбөр тооцоо, тэр дундаа Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын оруулсан хөрөнгө оруулалтыг нь хураан авсны нөхөн төлбөрийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс саадгүй шилжүүлэх.

### **Зургаадугаар зүйл**

Монголын тал энэхүү Хэлэлцээрийн дагуу Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын Монгол Улсын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалт хийсний үр дүнд авах орлого, тэр дундаа ногдол ашиг, хувь, хүү, лиценз болон комиссын урамшуулал, мөн бусад хөрөнгийг шууд болон шууд бусаар өмч хураах, улсын өмч болгох эсхүл албадан хураах, мөн өмч хураах, улсын өмч болгох эсхүл албадан хураахтай дүйцэхүйц бусад арга хэмжээнээс хамгаалах баталгаа олгоно.

Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага арилжааны гэрээг хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл түүний үр дүнд олсон хөрөнгөө мөнгөн, эсхүл биет хэлбэрээр чөлөөтэй буцаан авахад, түүнчлэн арилжааны гэрээг хэрэгжүүлэх явцад Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагад төлбөр тооцоог цаг тухайд нь бүрэн гүйцэд хийхэд Монголын тал баталгаа олгоно.

Шууд эсхүл шууд бусаар өмч хураах, улсын өмч болгох эсхүл албадан хураах мөн үр дагавраараа тэдгээртэй адил бусад арга хэмжээний үр дүнд хөндөгдсөн актив, эд хөрөнгө, эрх эсхүл ашиг сонирхлын нөхөн олговрыг Монголын тал нэн даруй олгоно. Нөхөн олговор нь Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын тодорхойлсон хараат бус үнэлгээний байгууллагын тогтоосон зах зээлийн үнэлгээний бүтэн үнийн дүнгээр олгогдох бөгөөд нөхөн олговрын хэмжээ нь хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээнээс багагүй байна. Мөн үнэлгээг хийхдээ өмч хураах, улсын өмч болгох эсхүл албадан хураах мөн эд хөрөнгө, эрх, ашиг сонирхлыг хураах бусад арга хэмжээ болон тэдгээртэй холбоотой эд хөрөнгө, эрх, ашиг сонирхлын зах зээлийн үнэлгээнд нөлөөлж болзошгүй сөрөг үр дагаврыг тооцохгүй.

### **Долдугаар зүйл**

Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага болон/эсхүл хамтарсан компанийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх Байгууламжийн үйл ажиллагаа болон бүх төрлийн хөрөнгө оруулалт, нийлүүлэлттэй холбоотой нөхцөл байдлыг доройтоход хүргэсэн өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээр нь үйлчлэхгүй болно.

Энэ зүйлд зааснаар энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш Монгол Улсын хууль тогтоомжид өөрчлөлт орж, татвар, тариф, хураамж, үүний дотор гаалийн болон бусад бүх төрлийн татварын төлбөр нэмэгдэх, гадаадын ажилчдын квот нэмэгдэх эсхүл багасах; эсхүл энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш шинэ татвар, тариф, хураамж, үүний дотор гаалийн болон бусад бүх төрлийн татварын төлбөр, гадаадын ажилчдын квот шинээр нэвтрүүлэх; түүнчлэн энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурах үед Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагад болон/эсхүл Хамтарсан компанид энэхүү Хэлэлцээрээр болон Монгол Улсын хууль тогтоомжоор олгож байсан хөнгөлөлт, давуу эрхийг цуцлах нь Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын нөхцөл байдал нь доройтсон гэж үзнэ.

### **Наймдугаар зүйл**

Энэхүү Хэлэлцээрийн зүйл, заалтыг хэрэгжүүлэх болон/эсхүл тайлбарлахад Талуудын хооронд үүссэн маргаан, санал зөрөлдөөнийг Талууд зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

### **Есдүгээр зүйл**

1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой маргаан, санал зөрөлдөөнийг Монголын болон Оросын талын итгэмжлэгдсэн байгууллагын хооронд зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэж, тэдгээр нь цаашид маргаанд оролцогч Талууд гэгдэнэ.

2. Хэрэв маргаан эхэлсэн өдрөөс хойш 2 сарын дотор шийдвэрлэгдэхгүй тохиолдолд Талуудын аль нэг талын хүсэлтээр маргааныг Оросын Холбооны Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим дахь Олон улсын арилжааны арбитрын шүүхэд түүний холбогдох дүрэм, журмын дагуу шилжүүлнэ.

3. Арбитрын шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд Талууд заавал биелүүлнэ.

### **Аравдугаар зүйл**

Энэхүү Хэлэлцээрт Талууд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр тусдаа протокол үйлдэн өөрчлөлт оруулж болно.

### **Арван нэгдүгээр зүйл**

Энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хооронд үйлчилж буй адил асуудал зохицуулсан бусад олон улсын гэрээний заалтуудаас давуу эрхтэй байна.

Энэхүү Хэлэлцээрт тусгагдаагүй бусад асуудалд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1995 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хэлэлцээрийн заалтууд үйлчилнэ.

### **Арван хоёрдугаар зүйл**

Энэхүү Хэлэлцээр нь Монголын талын хууль тогтоомжид заасан процедурыг хангаж, зохих шийдвэр гарсны дараа үйлчилж эхэлнэ.

Талууд хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын процедурыг Талууд хангасан тухай оролцогч талын сүүлчийн мэдэгдлийг дипломат шугамаар хүлээн авсан өдрөөс хойш 20 /хорин/ жилийн хугацаатай хүчин төгөлдөр байна.



Энэхүү Хэлэлцээрийг цуцалсан тохиолдолд хүчинтэй байх хугацаанд энэхүү Хэлэлцээрийн хүрээнд байгуулсан гэрээ (хэлэлцээр)-ийн дагуу хүлээсэн үүргийг биелүүлэхэд нөлөөлөхгүй. Хүлээсэн үүргийг биелүүлж дуусах хүртэл энэхүү Хэлэлцээрийн 5, 6, 7 болон 9 дүгээр зүйлийн заалтууд хүчин төгөлдөр хэрэглэгдэнэ.

Энэхүү Хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр монгол, орос хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эдгээр эх бичвэр нь адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 2024 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ

Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар, цаашид “Талууд” гэх,

Монгол, Оросын харилцааг цаашид бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулан,

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн Хэлэлцээрийн (цаашид “Хэлэлцээр” гэх) 10 дугаар зүйлийг харгалзан,

Дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

#### 1 дүгээр зүйл

Хэлэлцээрт дараах өөрчлөлтийг оруулна. Үүнд:

1) 4 дүгээр зүйлд:

1 дүгээр заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулна:

*“1. Талуудын эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын “Чингис хаан” олон улсын нисэх буудлын (ICAO-ийн нисэх буудлын код: ZMCK) агаарын хөлгийг түлшээр цэнэглэх дэд бүтцийг (цаашид “Байгууламж” гэх) удирдах болон ашиглах Хамтарсан компани байгуулна.”;*

5 дугаар заалтад “газрын тосны бүтээгдэхүүн” гэж заасныг “агаарын хөлгийн түлш” гэж өөрчлөх;

2) 7 дугаар зүйлийн 2 дугаар догол мөрийг хасах;

3) 9 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулна:

*“2. Хэрэв маргаан эхэлсэн өдрөөс хойш 2 сарын дотор шийдвэрлэгдэхгүй тохиолдолд Талуудын аль нэг талын хүсэлтээр маргааныг Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск хотод байрлах Беларусын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын*

арбитрын шүүхэд тус шүүхийн 2011 оны журмын дагуу хэлэлцүүлэхээр шилжүүлнэ”;

4) 11 дүгээр зүйлийн эхний догол мөрийг хасах;

5) 12 дугаар зүйлд:

Хоёрдугаар догол мөрөнд “20 жил” гэснийг “15 жил” гэж өөрчлөх;

Хоёрдугаар догол мөрний араас дараах агуулга бүхий догол мөр нэмэх:

*“Талуудын аль нэг тал нь нөгөө Талд Хэлэлцээрийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг дуусгавар болгох тухай хүсэлтийг Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх үндсэн хугацаа болон сунгагдсан дараа, дараагийн 5 жилийн хугацаа дуусгавар болохоос 1 жилийн өмнө бичгээр мэдэгдэх хүртэл Хэлэлцээрийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа аяндаа дараагийн 5 жилийн хугацаанд сунгагдана.”*

## 2 дугаар зүйл

Энэхүү Протокол нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын процедурыг дуусгавар болгосон тухай бичгээр дипломат шугамаар мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс, чингэхдээ Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.

\_\_\_\_\_ хотод \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дүгээр сарын \_\_\_\_ - ний өдөр монгол, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

### Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin\_medeelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003

